

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/43.

Арвайхээр сум

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед
авах зарим арга хэмжээний тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 18-ний өдрийн “Журам, заавар батлах тухай” 373 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Томуу томуу төст өвчний тархалтын үе шатанд тохирсон төлөвлөлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх “Тохиолдлын удирдлагын тогтолцоо”-ны багийн үйл ажиллагааг идэвхжүүлсүгэй.

2.Арвайхээр сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээг гэрийн эргэлтэд бүрэн шилжүүлэн, хөнгөн болон дунд хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг гэрээр эмчлэн хяналт тавьж, амбулаторийн цагийг 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний хугацаанд ажлын өдрүүдэд 19:00-22:00, амралтын өдрүүдэд 16:00-20:00 хүртэл уртасган ажиллуулсугай.

3.Уртасгасан цагаар ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтний илүү цагийн хөлсийг биеэр амраах болон хөдөлмөрийн хуулийн дагуу төсөвтөө багтаан шийдвэрлэхийг ахлах нягтлан бодогч (Б.Валя), өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров), Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Н.ОЮУНТУЯА